



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/274

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 11/01 дүгээр “Аймгийн 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” тогтоолын 2 дугаар хавсралтын 2-т тусгагдсан “Хархорин-Ус суваг” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт ус зөөврийн автомашин авах зардалд 40,000,000 (дөчин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Хархорин сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнахыг Хархорин сумын Засаг дарга (Г.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0589

D:My Doc. Zahiramj. Zasag darga